

ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН НОРМАТИВ,
ТЕХНИКИЙН БАРИМТ БИЧГИЙН ТОГТОЛЦОО
**МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН
НОРМ БА ДҮРЭМ**

АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН БАРИЛГА,
ЗАСВАРЫН АЖЛЫН ТӨСӨВ БОДОХ НОРМ
ЗЗБНБД 81-013-2024
(ТӨСӨЛ)

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
2024 ОН

ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН НОРМАТИВ, ТЕХНИКИЙН
БАРИМТ БИЧГИЙН ТОГТОЛЦОО

**МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН
НОРМ БА ДҮРЭМ**

АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН БАРИЛГА,
ЗАСВАРЫН АЖЛЫН ТӨСӨВ БОДОХ НОРМ

ЗЗБНБД 81-013-2024

(ТӨСӨЛ)

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

2024 ОН

МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН НОРМ БА ДҮРЭМ
АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН БАРИЛГА, ЗАСВАРЫН АЖЛЫН

ТӨСӨВ БОДОХ НОРМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэ нормын үндсэн зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрт авто зам, замын байгууламжийг шинээр барих, шинэчлэх, өргөтгөх, арчлах, засвар хийх ажлын өртгийг тодорхойлоход баримтлах арга зүй, зарчим, дарааллыг тогтоож, төсөв бодох үйл ажиллагааг нэг мөр болгон журамлахад оршино.

1.2. Энэхүү норм нь ажлын зураг, техникийн шаардлага, гэрээний бусад баримт бичгүүдийг үндэслэн Монгол Улсын холбогдох хууль, эрх зүйн актуудад нийцүүлэн, төсвийн суурь нормыг ашиглан авто зам, замын байгууламжийн төсөвт өртгийг тооцоход ашиглагдана.

1.3. Энэ нормыг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хийгдэх авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсвийн тооцоонд салбарын төрөл, хөрөнгийн эх үүсвэр, өмчлөлийн хэлбэр, харъяаллаас үл хамааран заавал мөрдөнө.

1.4. Энэхүү нормыг ашиглан тооцоолсон төсвийг улсын болон орон нутгийн төсөв, нийслэлийн төсөв, замын сан, гадаадын зээл, тусламжийн хөрөнгө болон тэдгээртэй адилтгах төсвийн бус эх үүсвэрээр санхүүжигдэх төсөл, хөтөлбөр, хувийн болон гадаадын компаниудын хөрөнгө оруулалтаар хэрэгжих авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын хөрөнгө оруулалт, санхүүжилт, эдийн засгийн үр өгөөжийг тооцох, тендерийн сонгон шалгаруулалтад бэлтгэх, тендер шалгаруулалт, түүнчлэн зохих хууль, тогтоомжийн дагуу шууд гэрээгээр гүйцэтгэх ажлын сонгон шалгаруулалт зэрэгт хэрэглэнэ.

1.5. Энэ нормыг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж буй хууль тогтоомж, Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын батлан гаргасан авто замын салбарын үнэ бүрдэл, төсвийн норм, нормативууд, эрх зүйн бусад баримт бичгийг үндэслэн боловсруулав.

Хоёр. Авто замын салбарын үнэ бүрдэл, төсвийн нормын

нийтлэг үндэслэл

2.1. Авто замын салбарын төсвийн нормчлол, үнэ бүрдлийн тогтолцоо нь авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөвт өртгийг тодорхойлоход зайлшгүй шаардлагатай төсвийн норм, нормативууд, холбогдох норм дүрэм, заавар, бусад баримт бичиг, эрх зүйн актуудаас (цаашид төсвийн норматив гэх) бүрдэнэ.

2.2. “Төсвийн норматив” гэдэг нь Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын батлан гаргасан төсвийн норм, норматив, үнэ, үнэлгээний эмхэтгэл, жишиг үнийн бүрдэл юм. Төсвийн нормативууд нь холбогдох бусад норм ба дүрэм, аргачлал, заавар, журмын хамтаар төсөвт өртгийг тодорхойлох үндэс болно.

2.3. Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын нэгж хэмжигдэхүүнд ноогдох нийт нөөцийн хэмжээг (ажилтны хөдөлмөр зарцуулалт, машин механизм, тоног төхөөрөмжийн ажиллах хугацаа, материалын хэрэгцээ) төсвийн норм гэж нэрлэнэ. Төсвийн нормын үндсэн зориулалт нь тухайн төрлийн ажлыг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай,

хүрэлцэхүйц хэмжээний нормативт нөөцийн хэмжээг тогтоох, үүний үндсэн дээр тухайн ажлын өртгийн үзүүлэлтийг тодорхойлоход оршино.

2.4. Төсвийн нормативыг холбогдох норм ба дүрэм, стандарт, техникийн шаардлага, технологийн дагуу барилга, засварын ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай бүх нөөцийн хэрэгцээт хэмжээг дундчилах зарчимд үндэслэн боловсруулна.

2.5. Төсвийн нормыг гадны хүчин зүйлс нөлөөлөхгүй, хэвийн нөхцөлд, тухайн ажлыг технологийн дарааллын дагуу гүйцэтгэхээр боловсруулна. Хэрэв хөдөлмөрийн хэвийн бус нөхцөл, онцгой нөхцөлд (хөдөлгөөнтэй, хэт хүйтэн, хэт халуун, давчуу, битүү, газрын дор, ажиллаж буй тоног төхөөрөмжид ойр гэх мэт) ажил гүйцэтгэвэл төсвийн нормд төвөгшлийн итгэлцүүр хэрэглэх бөгөөд итгэлцүүрийн хувь хэмжээ, ямар нөхцөлд ашиглах талаар төсвийн суурь норм, төсөв бодох нормд тодорхойлсон байна.

2.6. Хэрэв мөрдөж буй төсвийн нормын эмхэтгэлд зураг төсөлд тусгагдсан ажлыг гүйцэтгэх норм байхгүй, ойролцоо ажлын нормоор үнэлэх боломжгүй тохиолдолд тухайн ажлын төсвийн суурь нормыг зураг төслийн ажлын бүрэлдэхүүнтэй хамт боловсруулж, холбогдох журмын дагуу батлуулж мөрдөнө.

2.7. Авто замын салбарын үнийн бодлого нь авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөвт өртгийг бодитой тооцох, ажиллах хүн хүч, машин механизм, тоног төхөөрөмж, материал, бусад нөөцийг үр ашигтай ашиглах, зарцуулахад чиглэгдэнэ.

2.8. Төсөвт өртөг тооцоолох үндэслэл нь авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлыг гүйцэтгэх төслийн баримт бичиг, ажлын тоо хэмжээ, машин механизм, тоног төхөөрөмж, материалын хэрэгцээ шаардлага, үнэ, тээвэрлэх зай, орон нутгийн татвар, хураамжууд зэргийг багтаасан ажлын зураг төсөл, техникийн шаардлага, хүчин төгөлдөр мөрдөж буй төсвийн норматив, үнэ бүрдлийн тогтолцооны баримт бичгүүд байна.

2.9. Зураг төсөл, техникийн шаардлага, бусад баримт бичгийг үндэслэн төсөв бодох нормын дагуу тооцсон авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлыг гүйцэтгэх, ашиглалтад оруулахад шаардагдах мөнгөн хөрөнгийн нийлбэрийг нийт төсөвт өртөг гэнэ.

2.10. Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын нийт төсөвт өртөг нь хөрөнгө оруулалтын хэмжээг тодорхойлох, гүйцэтгэгч байгууллагын гүйцэтгэсэн ажлын тооцоо хийх, материалын тоо хэмжээ, машин цагийн хэрэгцээ, тээвэрлэх ачааны жин, зардлыг тодорхойлох, түүнчлэн нэгдсэн төсөвт байгаа бусад ажлын зардлыг санхүүжүүлэх, гүйцэтгэгч, захиалагч байгууллагын тайлан тэнцэл зохиох, бизнес төлөвлөгөө хийх суурь тооцоо болно.

2.11. Нэгдсэн төсвийн тооцооны дүн нь ашиглалтад оруулсан авто зам, замын байгууламжийн үндсэн хөрөнгийн өртгийг тогтоох үндэслэл болно.

2.12. Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын зураг төслийг боловсруулах шатанд хэрэглэгдэх төсвийн нормыг ажлын төрлөөр нь төсвийн суурь норм, томсгосон норм гэж ангилна.

2.13. Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төрлөөр тооцсон төсвийн суурь нормын (цаашид төсвийн суурь норм гэх) бүрэлдэхүүнд дараах нормууд орно. Үүнд:

- Авто замын барилгын ажлын төсвийн жишиг норм (ЗЗБНБД 83-25-2023)

- Төмөрбетон гүүр хоолойн барилгын ажлын төсвийн жишиг норм (ЗЗБНБД 83-28-2023)

- Авто зам, замын байгууламжийн арчлалт, засварын ажлын төсвийн жишиг норм (ЗЗБНБД

83-26-2023)

2.14. Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөвт өртгийг тодорхойлоход хязгаар тогтоосон дараах зардлын нормативыг ашиглана. Үүнд:

- Тээврийн жолооч, машин механизмын операторчидын цалингийн норматив
- Инженер, техникийн ажилтны цалингийн норматив
- Нэмэгдэл цалингийн норматив
- Алслалтын нэмэгдэл цалингийн норматив
- Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн норматив
- Ажлын багаж хэрэгслийн элэгдлийн зардлын норматив
- Ажлын талбайд ажиллах ажилтнуудад үйлчлэх нэг хүн.өдрийн зардлын норматив
- Удирдлага, зохион байгуулалтын зардлын норматив
- Ашгийн зардлын норматив
- ХАБЭА-н зардлын норматив
- Даатгалын зардлын норматив
- Техник, технологийн хяналтын (зөвлөх үйлчилгээ) зардлын норматив
- Захиалагчийн хяналтын зардлын норматив
- Магадлашгүй ажлын зардлын норматив
- Үнийн магадлашгүй ажлын зардлын норматив
- Норм, нормативын сангийн шимтгэлийн норматив
- Нэмэгдсэн өртгийн албан татварын норматив

2.15. Төсвийн суурь нормын эмхэтгэл нь техникийн хэсэг, төсвийн нормын хүснэгт, хавсралт, лавлахтай байна. Техникийн хэсэгт төсвийн нормын эмхэтгэлүүдийг хэрхэн хэрэглэх заавар, ажил гүйцэтгэх нөхцөлийг харгалзан төсвийн нормд итгэлцүүр хэрэглэх журам, түүнчлэн ажлын тоо хэмжээг хэрхэн тодорхойлох талаар заана.

2.16. Төсвийн суурь нормын хүснэгт, хавсралт лавлах нь дараах нөөцүүдийн норматив үзүүлэлтийг агуулсан байна. Үүнд:

- Ажилтны мэргэжлийн зэрэг, хэмжих нэгж
- Ажлын хөдөлмөр зарцуулалт (хүн цагаар)
- Машин механизм, тоног төхөөрөмжийн бүрэлдэхүүн, ажиллах хугацаа, (машин цагаар)
- Ажил гүйцэтгэхэд хэрэглэх материал, хийц эдлэлийн нэр төрөл, тэдгээрийн хэмжих нэгжээр илэрхийлсэн зарцуулалт, хэмжих нэгжийн нэгж хүнд

2.17. Томсгосон норм үнэлгээг төсвийн суурь нормыг үндэслэн боловсруулна.

Гурав. Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох аргачлал, баримтлах зарчим, төсвийн баримт бичгийн бүтэц

3.1. Зураг төслийн баримт бичгийн бүрдэл хэсэг болох авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсвийг төсвийн суурь нормыг үндэслэн боловсруулна.

3.2. Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлыг батлагдсан зураг төслийн дагуу гүйцэтгэнэ. Батлагдсан зураг төслийг үндэслэн төсвийн тооцоог хийх ба тухайн үед хүчин төгөлдөр мөрдөж буй норм дүрэм, тушаал шийдвэрийн дагуу тооцно.

3.4. Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөвт өртөг нь тооцоо хийж буй тухайн цаг үеийн жишиг үнээр тооцоологдсон байх ёстой. Харин авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хийх үед ээлжит санхүүгийн жилд гүйцэтгэх ажлын төсөвт өртгийг үнийн индексийн харгалзах системийг ашиглан, зах зээлийн үнийн хэтийн түвшинд тодорхойлно.

3.5. Тухайн жил буюу “авто замын барилгын ажлын улирал”-д эсвэл жил дамнан үргэлжлэн хийгдэх замын барилгын ажлын төсөвт өртөгт тусгагдах ажилтны цалингийн тариф, материал түүхий эдийн үнэ, автомашинаар ачаа тээвэрлэх тн.км-ын жишиг үнэ, машин механизм, тоног төхөөрөмжийн машин цагийн жишиг үнийн өөрчлөлтийг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулсан индексээр өөрчлөн тооцно.

3.6. Хэрэв тухайлсан ямар нэгэн ажилбарын өртгийг тооцоолоход шаардлагатай норм, норматив, эрх зүйн акт байхгүй бол түүнтэй ижил төстэй ажлын үнэлгээг хэрэглэж болно. Ийм боломжгүй бол шаардлагатай норм, үнэлгээг нэмэлт болгон боловсруулж, батлуулан мөрдөнө.

3.7. Суурь үнийг ашиглан төсвийн тооцоо (тухайн үеийн болон хэтийн) хийх үед авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын шууд зардлыг бүрдүүлэгч хэсгүүдэд (барилга угсралтын ажлын төрлөөр), эсхүл шууд зардлын дүн болон нэгж үнэ ба нийт үнэ, нийт төсөвт өртгийн дүнд индексийг ашиглаж болно.

3.8. Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл түүнээс эрх шилжүүлж авсан байгууллага нь авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажилд хэрэглэх төрөл бүрийн материал, хийц, эдлэхүүний үнийн судалгаа хийх, мэдээллийн санг бүрдүүлэх, баяжуулах, жил, улирал тутамд олон нийтэд мэдээлэх үүрэгтэй байна. Энэ нь үнэ, тарифын өөрчлөлтийн тооцоо хийх албан ёсны үндэслэл болно.

3.9. Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсвийн баримт бичиг нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

- а) Нэгж ажлын төсөв
- б) Объектын (шууд зардал) төсөв
- в) Барилга угсралтын ажлын төсөв (НӨАТ-гүй)
- г) Барилга угсралтын ажлын төсөв (НӨАТ-тай)
- д) Нэгдсэн төсвийн тооцоо
- е) Хөрөнгө оруулалтын зардлын тооцоо
- ё) Нэгж үнэ ба нийт зардлын тооцоо

3.10. Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсвийн тооцооны баримт бичгийг бүрдүүлэхдээ дараах үндсэн дэс дарааллыг баримтлана. Үүнд:

А. Бэлтгэл ажил:

- Авто зам, замын байгууламжийн зураг төсөл, техникийн шаардлага бусад бичиг баримттай (тайлбар бичиг, геологи, геодези, байгаль орчны тайлан г.м) танилцах, ажлын тоо хэмжээг шалгах;
- Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй жишиг үнэ, тариф, норм, эрх зүйн баримт бичиг, холбогдох суурь нормуудыг бүрдүүлэх;

- Төсвийн суурь нормын ажлын нэр төрөл, хэмжих нэгжид тохируулан төсвийн тооцоо хийх, ажлын зураг төсөл, техникийн шаардлагын дагуу төсөв бодох ажлын үе шат, төрөл зүйлийн жагсаалт гаргах, төсвийн суурь нормын үндэслэлийг бичих;
- Суурь нормд байхгүй ажилбаруудын үнэлгээг ижил төстэй ажлаар, эсвэл шинээр тооцоолох;
- Суурь норм, төсөв бодох нормд байгаа итгэлцүүрийг ямар ажилд, өөрөөр хэлбэл ажлын ямар онцлог нөхцөлд ашиглахыг тогтоох, баримт бичгийг бүрдүүлэх, тооцоонд ашиглах;
- Тухайн төсөв бодоход хэрэглэгдэх үнэ бүрдлийн талаарх төрийн захиргааны байгууллагын гаргасан шийдвэр, тогтоол, дүрэм журам, холбогдох баримт бичгийг бүрдүүлэх;

Б. Төсвийн тооцоо хийх:

- Ажилтны хөдөлмөр зарцуулалт, нийт цалингийн зардлын тооцоо
- Ажилтны нэмэгдэл цалингийн зардлын тооцоо (нэмэгдэл, нэмэгдэл хөлс, ээлжийн амралт, шагнал урамшуулал)
- Инженер, техникийн ажилтны (ИТА) цалингийн зардлын тооцоо
- Материал, хийц эдлэлийн хэрэгцээ
- Материалын зардлын тооцоо
- Материалын тээврийн зардлын тооцоо
- Тээврийн жолоочийн цалингийн зардлын тооцоо
- Машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалтын зардлын тооцоо
- Машин механизмын операторчидын цалингийн зардлын тооцоо
- Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын тооцоо
- Ажлын багаж хэрэгслийн зардлын тооцоо
- Авто замын барилга, арчлалт, засварын ажлын талбайд ажиллах ажилтнуудад үйлчлэх зардлын тооцоо
- Нүүлгэн шилжүүлэх ажил, түр барилгын элэгдлийн зардлын тооцоо
- Удирдлагын зардлын тооцоо
- Нийт ашгийн зардлын тооцоо
- ХАБЭА-н зардлын тооцоо
- Барилга угсралтын ажлын даатгалын тооцоо
- Нэмэгдсэн өртгийн албан татварын зардлын тооцоо
- Бусад зардлын тооцоо гэх мэт

В. Төсвийн тооцоог гүйцэтгэх:

- Объектын (шууд зардал) төсвийн тооцоо хийх
- Үйл ажиллагааны зардлын тооцоо хийх
- Барилга угсралтын ажлын төсвийн тооцоо хийх
- Нэгдсэн төсвийн тооцоо хийх
- Хөрөнгө оруулалтын зардлын тооцоо хийх гэх мэт дарааллаар төсвийн баримт бичгийг бүрдүүлнэ.

3. ОБЪЕКТЫН ТӨСВИЙН ТООЦОО (ШУУД ЗАРДАЛ)

3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

3.1.1. Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлыг хийж гүйцэтгэхдээ талбай дээр гардаг материаллаг зардлаар (шууд зардлаар) объектын төсвийн тооцоог хийнэ.

3.1.2. Объектын төсвийн тооцоог авто замын барилга, засварын ажлыг гүйцэтгэх анхан шатны үйлдвэрлэлийн нэгж, байгууллага хэрэглэх ба ерөнхий болон туслан гүйцэтгэгч байгууллагын хийх ажлын хэмжээг тодорхойлоход ашиглана.

3.1.3. Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөвт өртгийг тооцохдоо тухайн объектын зураг төсөлд тусгасан ажлын тоо хэмжээ, техникийн шаардлагад заасан технологийн дарааллыг үндэслэн, төсвийн тооцооны бүлэг тус бүрээр гүйцэтгэнэ.

3.1.4. Бүлэг нь дараах байдалтай байж болно. Үүнд:

А. Авто замын барилгын ажил

- а) Түр барилга ба үйлдвэрлэлийн бэлтгэл ажил
- б) Замын трасс сэргээж, гадаслах
- в) Материалын шинжилгээ туршилтын ажил
- г) Замын трасс, талбайн цэвэрлэгээний ажил
- д) Карьер, шороон орд нээх, нөхөн сэргээх ажил
- е) Түр болон туслах замын ажил
- ё) Замын далан, ухмалын ажил
- ж) Замын суурийн ажил
- з) Замын хашлага байрлуулах ажил
- и) Замын хучилтын ажил
- й) Замын хайрган хөвөө байгуулах ажил
- к) Ус зайлуулах энгийн байгууламжийн ажил
- л) Явган хүн ба унадаг дугуйн замын ажил
- м) Замын тэмдэглэгээний ажил
- н) Замын тоноглолын ажил
- о) Замын тохижилтын ажил
- ө) Өрөмдлөгө, тэсэлгээний ажил
- п) Материал бэлтгэх ажил
- р) Хог хаягдал цэвэрлэх
- с) Авто зам, замын байгууламжийг улсын ашиглалтад оруулах
- т) Хүйтний улиралд хийгдэх замын ажил
- у) Бусад ажил
- ф) Үйлдвэр, заводыг ачиж буулгах, угсрах, хураах ажил
- х) Замын бүх ажлууд

Б. Төмөрбетон гүүр, хоолой, хиймэл байгууламжийн ажил

- а) Барилгын талбайн бэлтгэл
- б) Гүүр, хоолойн материалын ба хийц бүтээцийн үйлдвэрлэлийн бэлтгэл ажил
- в) Гүүрийн тулгуурын энгийн суурь
- г) Өрөмдмөл баганат суурь байгуулах
- д) Захын болон завсрын тулгуур байгуулах
- е) Алгаслалын бүтээц байрлуулах ба байгуулах

- ё) Зорчих хэсэг байгуулах
- ж) Хэв гажилтын заадас байгуулах
- з) Урсгал залах далан байгуулах
- и) Далан сувгийн бэхэлгээ
- й) Төмөр бетон хоолойн барилга
- к) Арматур хүчитгэх
- л) Лабораторийн туршилт, шинжилгээ
- м) Объектыг ашиглалтад оруулах

В. Арчлалт, засварын ажил

- а) Шороон далан, суурь хөвөө ба шуудууны арчлалт, засварын ажил
- б) Авто замын шороон далан, хучилтын өргөтгөлийн ажил
- в) Хучилтгүй зам болон хөнгөвчилсэн шилжилтийн төрлийн хучилтын арчлалт, засварын ажил
- г) Хучилттай авто замын арчлалт, засварын ажил
- д) Тэмдэг, тэмдэглэгээ, тоноглолын арчлалт, засварын ажил
- е) Модон гүүрийн арчлалт, засварын ажил
- ё) Ус өнгөрүүлэх хоолойн арчлалт, засварын ажил
- ж) Төмөрбетон гүүрийн арчлалт, засварын ажил
- з) Өвлийн арчлалт, засварын ажил
- и) Бусад ажил

3.1.5. Төсвийн тооцоон дахь шууд зардлыг тодорхойлоход авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсвийн суурь нормууд, тэдгээрийн хавсралтуудаас дараах үндсэн өгөгдлүүдийг ашиглана. Үүнд:

а. Ажлын хөдөлмөр зарцуулалт (хүн.цаг)-аливаа ажлыг гүйцэтгэх замын барилгын ажилтны цалинг тодорхойлох үндсэн өгөгдөл

б. Зам барилгын машины ажиллах цаг—замын барилгын үе шатны ажлуудад ашиглагдах машин механизм, тоног төхөөрөмжийн хэрэгцээ (машин.цаг)

в. Материал ба хийц эдлэлийн зарцуулалт-материал ба хийц эдлэлийн орцын норм. (м³, м², тн, у/м, кг, ш) зэрэг биет нэгжээр хэмжигдэнэ.

г. Материал, хийц эдлэлийн тээвэрлэлт ба нүүлгэн шилжүүлэх ажил—тээвэрлэлтийн зайнаас хамаарч авах тээврийн тариф. (тн.км)

д. Түр барилгын элэгдлийн хугацаа (жил, сар)

3.1.6. Объектын (шууд зардал) төсөвт өртөгт нийт цалин, материалын зардал, тээврийн зардал, машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалтын зардал, эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, ажлын багаж хэрэгслийн элэгдлийн зардлыг оруулж тооцно.

3.1.7. Төсвийн бүрдэл хэсгүүдийн тооцоог нэг бүрчлэн хийсний дараа объектын нэгдсэн тооцоог зам барилгын тодорхой ажил, эсвэл бүлэг ажлаар нь тооцож Объектын төсвийг Маягт №2-н дагуу нэгтгэнэ.

3.1.8. Зөвхөн шууд зардлаар тооцох объектын төсөв нь талбайн ИТА-ны гарын авлага болох бөгөөд уг тооцоог ажлын төсөв гэж нэрлэж болно.

3.2. НИЙТ ЦАЛИНГИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

3.2.1. Ажилтны хөдөлмөр зарцуулалтыг тооцохдоо ажлын зургийг үндэслэн тодорхойлсон тоо хэмжээг нэгж ажлын хөдөлмөр зарцуулалтаар үржүүлж нэгтгэн тооцно. Ажилтны хөдөлмөр зарцуулалт, нийт цалингийн зардлын тооцоог Маягт №1-1-ийн дагуу тооцно.

3.2.2. Ажилтны хөдөлмөр зарцуулалтыг Авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан “Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодоход хэрэглэх ажилтны цагийн тарифт цалингийн жишиг”-ээр үржүүлж, төсөвт тусгагдсан ажилтны үндсэн цалингийн хэмжээг тодорхойлно. (Хавсралт №1)

3.2.3. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалын хавсралтаар батлагдсан “Газрын доор, хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөл”-д ажиллаж байгаа ажилтны ажил, мэргэжлийн жагсаалтад нийцүүлэн хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлийн нэмэгдлийн хувь хэмжээг Авто замын салбарын хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт хамт (тариф)-ын хэлэлцээрээр тогтоож, Авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

3.2.4. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалын хавсралтаар батлагдсан “Газрын доор, хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөл”-д ажиллаж байгаа ажилтны ажил, мэргэжлийн жагсаалтын дагуу авто замын салбарын хөдөлмөрийн хэвийн бус (хүнд, хортой) нөхцөлд ажиллаж байгаа ажилтны хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлийн нэмэгдлийг төсөвт тооцно. (Хавсралт №5)

3.2.5. Хөдөлмөрийн хэвийн бус (хүнд, хортой) нөхцөлд ажиллаж байгаа ажилтны хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлийн нэмэгдлийг тооцохдоо ажилтны үндсэн цалинг 10.8 хувиар нэмэгдүүлэн тооцно.

3.2.6. Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу ажилтныг орон нутгийн цагаар 22 цагаас 06 цаг хүртэлх хугацаанд шөнийн цагаар ажилласан ажилтны үндсэн цалинг 20 хувиар нэмэгдүүлэн тооцно.

3.2.7. Инженер, техникийн ажилтны цалинг төсвөөр тооцож гарсан ажилтны цалин, тээврийн жолоочийн цалин, машин механизмын операторчидын цалингийн нийлбэр дүнгээс авто замын барилга, засварын ажилд 20 хувиар, төмөрбетон гүүрийн барилга, засварын ажилд 25 хувиар тооцно.

3.2.8. Олон улс, улсын чанартай авто зам, замын байгууламжийн арчлалт, урсгал болон гэнэтийн хүчин зүйлээс хамаарсан засвар, ээлжит засварын ажилд инженер, техникийн ажилтны цалинг төсвөөр тооцож гарсан ажилтны үндсэн цалин, тээврийн жолоочийн цалин, машин механизмын операторчидын цалингийн нийлбэр дүнгээс 25 хувиар тооцно.

3.2.9. Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын нэмэгдэл цалинг (нэмэгдэл, нэмэгдэл хөлс) ажилтны цалин, тээврийн жолоочийн цалин, машин механизмын операторчидын цалингийн нийлбэр дүнгээс 40 хувиар тооцно.

3.2.10. Нийт цалингийн хэмжээг төсөвт тусгагдсан ажилтны үндсэн цалин, тээврийн жолоочийн цалин, машин механизмын операторчидын цалин, инженер, техникийн ажилтны цалин, нэмэгдэл цалин, алслалтын нэмэгдэл цалингийн нийлбэрээр тогтооно.

3.2.11. “Авто зам, замын байгууламжийг барих, арчлах, засварлах ажлын нормативт хугацаа, гүйцэтгэгчээс талбайд ажиллах ИТА-ны тоо, үе шатны ажилд зарцуулах цагийн норм”, хариуцан гүйцэтгэх ажлын хэмжээг харгалзан “Хөдөлмөрийн тухай хууль”-д нийцүүлэн цалин хөлсийг тооцож ИТА-ны цалингийн нормативыг тогтооно.

3.2.12. УИХ, Засгийн газраас цалин хөлс, тэтгэвэр тэтгэмжийг нэмэгдүүлэхтэй холбоотой тогтоол шийдвэрийг үндэслэн инфляци, салбарын хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулан “Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодоход хэрэглэх ажилтны цагийн тарифт цалингийн жишиг”-ийг жил бүр шинэчлэн боловсруулж, Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн 3 талт Үндэсний хорооны тогтоол, тушаал шийдвэр, дүрэм журамд нийцүүлэн салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Ажил олгогчийн болон Ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах салбарын байгууллагууд харилцан тохиролцож, хамтын гэрээ, хэлэлцээрийн үр дүнг Авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр батлуулан авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсвийн тооцоонд хэрэглэнэ.

3.2.13. “Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодоход хэрэглэх ажилтны цагийн тарифт цалингийн индекс”-ийг Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу хамтын гэрээ, хэлэлцээр, батлагдсан журмын дагуу тооцож Авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр батлуулан тухайн жилийн батлагдсан цалингийн индексийн өсөлтийн хувиар авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсвийн цалингийн зардлыг өсгөж тооцно.

3.2.14. Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын гүйцэтгэгч байгууллага нь улсын нийслэлээс алслагдсан зайд ажил гүйцэтгэх тохиолдолд алслалтын нэмэгдэл цалинг тооцно. Алслалтын нэмэгдэл цалин нь ажилтнуудыг алслагдсан бүс нутагт ажиллахыг урамшуулах, амьдралын өртөг өндөртэй газарт ажиллах, амьдрахад нь дэмжлэг үзүүлэх, ажилтнуудын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилготой юм.

3.2.15. Алслалтын нэмэгдэл цалинг ажилтны цалин, тээврийн жолоочийн цалин, машин механизмын операторчидын цалин болон инженер, техникийн ажилтны цалингийн нийлбэрээс дараах хувь хэмжээгээр тооцно. (Хүснэгт № 01)

Хүснэгт № 01

Тойргийн хүрээ	Улаанбаатар хотоос алслагдсан тойргийн хэмжээ, км-ээр	Цалинг нэмэгдүүлэх хэмжээ /хувиар/
I	100-300	10
II	301 – 600	15
III	601 – 1000	20
IV	1001 – ээс дээш	25

3.2.16. Алслалтын нэмэгдэл цалингийн хувь хэмжээг Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу Засгийн газрын гишүүн, Ажил олгогчийн болон Ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах салбарын байгууллагууд харилцан тохиролцож хамтын гэрээнд тусгана.

3.3. МАТЕРИАЛ БОЛОН ТЭЭВРИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

3.3.1. Материалын зардлын тооцоо нь авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажилд шаардагдах материалын нийт хэрэгцээ шаардлага, өртгийг тооцоолох үйл явц юм.

3.3.2. Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажилд шаардагдах материалын нийт зардлыг тооцохдоо материалын жагсаалт, тоо хэмжээг гаргах, материал тус бүрийн

зах зээлийн нэгж үнийн судалгаа хийж гүйцэтгэнэ. Материалыг хадгалахтай холбоотой нэмэлт зардлыг материалын зардалд нэмж тооцно.

3.3.3. Төсвийн суурь нормд тухайн ажилд шаардлагатай материал, эдлэхүүн, хийц бүтээцийн хэрэгцээт нөөцийг нэр төрлөөр нь тусгаж, материалын хэмжих нэгж, хэмжих нэгжийн нэгж хүндийг заасан байна.

3.3.4. Материалын нөөцийн нормативт хэрэгцээг дараах зүйлсийг үндэслэн тодорхойлно.

- Нэгбүрчилсэн төсөвт материалын нөөцийн нормативт хэрэгцээг тодорхойлохдоо төсвийн суурь нормын материал зарцуулалтын хэмжээг ажлын зургаар тооцож гаргасан тоо хэмжээгээр үржүүлж тогтооно.

3.3.5. Материал, тээврийн зардлын тооцоог гаргахын тулд ажлын зураг, техникийн шаардлагыг үндэслэн гаргасан нийт материалын хэрэгцээ, тээвэрлэх ачааны хүндийн жинг тооцож гаргана. Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажилд шаардагдах материалын хэрэгцээ, зардлын тооцоог Маягт №1-2-н дагуу тооцно.

3.3.6. Төсвийн суурь нормд бетоны арматурыг дундаж (орц) хэмжээгээр тооцсон байдаг учраас зураг төсөлтэй уялдуулан тооцно. Төсвийн нормд тусгагдаагүй материал хэрэглэхээр зураг төсөлд тусгагдсан тохиолдолд материалын шинж чанарыг судлан, орц, жинг зөв тогтоон төсөвт тусгаж болно.

3.3.7. Төсвийн тооцоонд материалын зардлыг тухайн объектын ажлын зураг, техникийн шаардлага, ажлын тоо хэмжээг үндэслэсэн материал, хийц, эдлэхүүний (тн, м², м³, у.м, кг, ш гэх мэт) авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажилд шаардлагатай тоо хэмжээ ба материалын төрөл тус бүрт харгалзах зах зээлийн үнийг ашиглан тооцно.

3.3.8. Төсвийн тооцооны материалын зардлын тооцоонд нэмэгдсэн өртгийн албан татварыг оруулж тооцохгүй.

3.3.9. Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажилд хэрэглэх аливаа материалын үнийг ажил гүйцэтгэж буй бүс нутгийн зах зээлийн дундаж үнээр авч төсвийн тооцоонд тусгана.

3.3.10. Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажилд хэрэглэх материал, хийц, эдлэхүүний үнэ бүрдэлт дараах нийтлэг жишигтэй байна. Үүнд:

а) Импортын материал–ын үнэ дараах томъёогоор тодорхойлогдоно.

$$Y_{\text{ИМП}} = B * K + T3^1 + \Gamma T + H\Theta AT + T3^2 + БНБН + T3^3 + БН$$

Энд: В- уг материалын импортын үнэ; К-валютыг төгрөгт шилжүүлэх илтгэлцүүр; T3¹- гадаад тээврийн зардал, энэ тээврийн зардлыг валютаар тооцоод төгрөгт шилжүүлж тооцно. ГТ- гаалийн татвар; HΘAT- нэмэгдсэн өртгийн албан татвар; T3²-гаалийн татвар төлөх хилийн шалгах цэгээс төмөр зам, авто тээврийн цэг хүрэх зардал; БНБН- бэлтгэн нийлүүлэгч байгууллагын нэмэгдэл. Энэ нь үйл ажиллагааны зардал ба ашгийн нэмэгдлээс бүрдэнэ. T3³-бэлтгэн нийлүүлэгчээс объект (бирж) хүртэл тээвэрлэх зардал бөгөөд энэ зардлыг бэлтгэн нийлүүлэгч тал хариуцна, БН- биржийн болон байгууллагын нэмэгдэл;

б) Эх орны үйлдвэрийн материал

Эх орны үйлдвэрийн материалын үнэ дараах томъёогоор тодорхойлогдоно.

$$Y_{\text{ЭХ ОРОН}} = БУ + H\Theta AT + ББ + БЗ$$

БУ- үйлдвэрийн үнэ; HΘAT- нэмэгдсэн өртгийн албан татвар; ББ- баримтын үнэ(падаан зэрэг нягтлангийн зардал), БЗ- буулгах зардал. Эх орны материалыг агуулахаар дамжуулахгүйгээр шууд объект дээр буулгана гэж тооцно.

в) Зам барилгын ажлыг гүйцэтгэгч байгууллагын өөрөө бэлтгэх материал

$$Y_{\text{өөрөө}} = BY + BЗ$$

BY- материал бэлтгэлийн үнэ. Тухайлбал суурийн буталсан чулуун материалыг бэлтгэх үнэд чулууг олборлох газрыг судалж тогтоох, ухаж, боловсруулалт хийх овоолох, ачиж буулгах, ажилчдын томилолтын зардал, хээрийн нэмэгдэл багтана. БЗ- буулгах зардал

3.3.11. Материалын тээврийн зардлын тооцоог Маягт №1-3-н дагуу тооцно.

3.3.12. Төсвийн тооцооны суурь нормоор тооцсон материал, эдлэхүүн, хийц бүтээцийн нормативт хэрэгцээг нэр төрлөөр нь нэгтгэж тээврийн зардлын тооцоог хийнэ.

3.3.13. Төсвийн тооцоонд материалын нөөцийн хэмжээг нэгж хүнд, сийрэгжилтийн коэффициентээр үржүүлж нийт жинг гаргана.

3.3.14. Тээврийн зардлын тооцоо нь авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажилд шаардагдах материалыг тээвэрлэх ажилд гарах зардлуудыг нарийвчлан тооцоолж, нийт зардлыг тодорхойлох үйл явц юм.

3.3.15. Материал, эдлэхүүн, хийц бүтээцийн нийт жинг тээвэрлэх зайн хэмжээ, ачааны зэргийг тогтоон автомашинаар ачаа тээвэрлэх тн.км-ын жишиг тарифаар үржүүлэн тээврийн зардлыг тооцно.

3.3.16. Төсвийн тооцоог хялбарчлах зорилгоор тээврийн зардлын тооцоонд материалыг бүлэглэж тооцож болно. (Үйлдвэрээс тээвэрлэх материал, шороон ордоос тээвэрлэх материал, УБ хотоос тээвэрлэх материал, аймаг, сумын төвөөс тээвэрлэх материал, хилийн боомтоос тээвэрлэх материал гэх мэт)

3.3.17. Ачааны зэргийг зарим зөвшөөрөгдөх тохиолдолд дараах хэлбэрээр хялбарчлан тооцож болно.

а) Тээврийн хэрэгслийн даацанд хүртэл ачаалж болох ачаа буюу эвдэрч хэмхрэхгүй ачаа - I зэрэг

б) Тээврийн хэрэгслийн даацанд хүртэл ачаалж болохгүй ачаа буюу хагарч гэмтэх ачаа - II зэрэг

в) Тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл хэрэглэх ачаа буюу тэсэрч, дэлбэрэх ачаа - III зэрэг

3.3.18. Тээврийн тарифыг тухайн асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан ачааны зэрэг, тээврийн зайнаас хамааруулан сонгоно. (Хавсралт 3-1, Хавсралт 3-2)

3.3.19. Тээврийн жолоочийн цалингийн зардлын хэмжээг тооцохдоо тээврийн нийт зардлын дүнгээс 8.7 хувиар бодож ажилтны хөдөлмөр зарцуулалт, цалингийн зардлын тооцооны “Тээврийн жолоочийн цалин”-д тусгах ба нэгдсэн төсвийн тооцоонд тээврийн нийт зардлын дүнгээс цалингийн зардлыг хасаж тооцно.

3.4. МАШИН МЕХАНИЗМ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН АШИГЛАЛТЫН ЗАРДЛЫН ТООЦОО

3.4.1. Нэгбүрчилсэн төсвийн бүрэлдэхүүнд машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалтын зардлыг төсвийн нормоор тооцож гаргасан машин механизм, тоног төхөөрөмжийн ажиллах хугацаа, /машин цагаар/ болон нэг машин цагийн жишиг үнийг

үндэслэн тодорхойлно. Төсвийн суурь нормд тухайн ажилд хэрэглэгдэх машин механизм, тоног төхөөрөмжийн нэр төрөл, машин цагийн тоо хэмжээг заасан байна.

3.4.2 Замын барилгын ажлын машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалтын зардал нь тэдгээрийн зам барилгын ажил гүйцэтгэх үед ашиглах зардал (машин цаг)-аар тодорхойлогдоно.

3.4.3. Замын барилгын ажлын машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалтын зардлыг Маягт №1-4-н дагуу тооцно.

3.4.4. Замын барилгын ажлын машин механизмын операторчидын цалинг машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалтын зардлын тооцооны нийт дүнгээс 8.7 хувиар бодож ажилтны хөдөлмөр зарцуулалт, цалингийн зардлын тооцооны “Машин механизмын операторчидын цалин”-д тусгах ба нэгдсэн төсвийн тооцоонд машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалтын зардлын тооцооны дүнгээс цалингийн зардлыг хасаж тооцно.

3.4.5. Төсвийн тооцоонд нэгж машин цагийн үнийг тодорхойлохдоо тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан “Авто зам, замын байгууламжийн машин механизмын ашиглалтын нэг машин цагийн үнэ”-ийг баримтлана. (Хавсралт №2)

3.4.6. Машин механизм, тоног төхөөрөмжийн нэгж машин цагийн батлагдсан үнэлгээ байхгүй тохиолдолд хүчин чадал ойролцоо машин механизм, тоног төхөөрөмжийн үнээр үнэлнэ.

3.4.7. Гүйцэтгэгч байгууллага машин механизмын техникийн суурь өгөгдөл болон өөрийн өртөг, ашиглалтын үнийн тухай мэдээллийг цахим хэлбэрт оруулж, бүртгэлийг тогтмол хөтөлж байх ёстой.

3.4.8. Машин механизм, тоног төхөөрөмжийн болон засвар үйлчилгээний ажилтны хөдөлмөрийн хөлсийг машин механизм, тоног төхөөрөмжийн нэг машин цагийн жишиг үнэд тусгана.

3.5. ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

3.5.1. Монгол Улсын “Нийгмийн даатгалын ерөнхий хууль”-ийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Ажил олгогч болон энэ хуулийн 7.2, 7.3, 7.4, 7.5-д заасан даатгуулагч дараах хувь хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын шимтгэл төлнө” гэж заасан. (Хүснэгт №2)

Хүснэгт №2

№	Нийгмийн даатгалын төрөл	Ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/	Даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/
1	Тэтгэврийн даатгал	8.5	8.5
2	Тэтгэмжийн даатгал	1.0	0.8
3	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал	0.5, 1.5, 2.5	-

4	Ажилгүйдлийн даатгал	0.5	0.2
	Шимтгэлийн дүн	10.5, 11.5, 12.5	9.5

3.5.2. Монгол Улсын “Нийгмийн даатгалын ерөнхий хууль”-д заасны дагуу ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг ажилтны үндсэн цалин, тээврийн жолоочийн цалин, машин механизмын операторчидын цалин, инженер, техникийн ажилтны цалин, нэмэгдэл цалин, алслалтын нэмэгдэл цалингийн нийлбэр буюу нийт цалингийн дүнгээс 12.5 хувиар тооцно. (Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт өөрчлөлт орсон тохиолдолд хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.)

3.5.3. Монгол Улсын “Эрүүл мэндийн даатгалын тухай хууль”-ийн 8 дугаар зүйлийн 8.1.1-т “энэ хуулийн 6.1.1-д заасан даатгуулагчийн сард төлөх шимтгэлийн хувь хэмжээг түүний хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 4-өөс доошгүй хувиар жил бүр”, 8.2-т “Шимтгэлийг дараах байдлаар эрүүл мэндийн даатгалын санд хариуцан төлнө”, 8.2.1-т “энэ хуулийн 6.1.1-д заасан даатгуулагчийн шимтгэлийг даатгуулагч, ажил олгогч тэнцүү хувь хэмжээгээр сар бүр” гэж заасан.

3.5.4. Монгол Улсын “Эрүүл мэндийн даатгалын тухай хууль”-д заасны дагуу ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг ажилтны үндсэн цалин, тээврийн жолоочийн цалин, машин механизмын операторчидын цалин, инженер, техникийн ажилтны цалин, нэмэгдэл цалин, алслалтын нэмэгдэл цалингийн нийлбэр буюу нийт цалингийн дүнгээс 2 хувиар тооцно. (Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсон тохиолдолд хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.)

3.6. АЖЛЫН БАГАЖ ХЭРЭГСЛИЙН ЭЛЭГДЛИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

3.6.1. Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын багаж хэрэгслийн элэгдлийн зардал нь тухайн ажлыг гүйцэтгэхэд ашиглагдах багаж хэрэгслийн ашиглалтын явцад үүсэх элэгдэл, хорогдлын өртөг юм. Үүнд:

1. Лабораторийн багаж тоног төхөөрөмж (прокторын хэв, алх, индикатор гэх мэт)-ийн элэгдэл
2. Гар багаж, төхөөрөмж (хүрз, лоом, алх, метр гэх мэт)-ийн элэгдэл
3. Геодезийн хэмжих багаж, төхөөрөмж (нивелир, тахеометр, GPS гэх мэт)-ийн элэгдэл гэх мэт

3.6.2. Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын багаж хэрэгслийн элэгдлийн зардлыг ажилтны үндсэн цалингийн дүнгээс 5 хувиар тооцож төсөвт тусгана.

3.7. АЖЛЫН ТАЛБАЙД АЖИЛЛАХ АЖИЛТНУУДАД ҮЙЛЧЛЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

3.7.1. Ажилтны эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор авто замын барилга, арчлалт, засварын ажлын талбайд ажиллаж буй ажилтнуудыг халуун хоол, цайгаар хангах үйлчилгээг "Ажлын талбайд ажиллах ажилтнуудад үйлчлэх зардал" гэж нэрлэнэ.

3.7.2. Хот болон төв суурин газар, хөдөө орон нутагт ажиллах ИТА, замчин, машин механизмын операторчин, жолооч, тээвэрчдэд ажилласан өдөр тутамд 14000 төгрөгийн "Ажлын талбайд ажиллах ажилтнуудад үйлчлэх зардал"-ыг тооцож төсөвт тусгана.

3.7.3. Төсөвт тусгах "Ажлын талбайд ажиллах ажилтнуудад үйлчлэх зардал"-ын хэмжээг ИТА-ны нийт зарцуулах цаг (хүн.цаг), ажилтны хөдөлмөр зарцуулалт, нийт цалингийн зардлын тооцооны нийт хөдөлмөр зарцуулалтын хэмжээ (хүн.цаг), машин механизм, тоног төхөөрөмжийн нийт машин цагийн тоо (маш.цаг), тээврийн зардал, нүүлгэн шилжүүлэх зардлын тээврийн нийт хөдөлмөр зарцуулалтын (хүн.цаг) нийлбэрийг ажлын нэг өдрийн үргэлжлэх хугацаа (7.97)-д хувааж ногдворыг нэг хүн.өдрийн ажилтнуудад үйлчлэх зардал болох 14000 төгрөгөөр үржүүлж гаргана.

3.7.4. "Ажлын талбайд ажиллах ажилтнуудад үйлчлэх зардал"-ын тооцооны ИТА-ны нийт зарцуулах цагийг "Авто зам, замын байгууламжийг барих, арчлах, засварлах ажлын нормативт хугацаа, авто зам, гүүрийн барилга, арчлалт, засварын ажлын үе шатны ажлуудад ноогдох ИТА-ны цагийн томсгосон норм"-ын үе шатны ажилд гүйцэтгэгчийн ИТА-ны зарцуулах цагийн нормыг үндэслэн тооцож авна.

3.7.5. Тээвэр, нүүлгэн шилжүүлэх ажлын хөдөлмөр зарцуулалт (хүн.цаг)-ийг бодохдоо дараах томъёогоор бодно.

$$T_{\text{хц}} = \left[\frac{A_{\text{ж}} * X_{\text{з}}}{Q_{\text{б}}} \right] : U_{\text{д}} * 1.2$$

$T_{\text{хц}}$ – тээврийн хөдөлмөр зарцуулалт (хүн.цаг)

$A_{\text{ж}}$ - тухайн материалын нийт жин (тн)

$X_{\text{з}}$ - тухайн материалыг тээвэрлэх тээврийн зай (км)

$Q_{\text{б}}$ - машины даац (тн)

$U_{\text{д}}$ - дундаж хурд (км.цаг)

1.2 - цагийн алдагдал тооцсон коэф

3.7.6. Материалын тээвэр, нүүлгэн шилжүүлэх зардлын тээврийн хөдөлмөр зарцуулалтын тооцоонд технологийн тээврийн машины даацыг 25 тн, дундаж хурдыг 20 км/цагаар, холын тээвэрт машины даацыг 30 тн, дундаж хурдыг 60 км/цагаар тооцно.

- Технологийн тээвэр нь авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлыг хийж гүйцэтгэх технологийн дагуу төслийн талбай дээр материалыг нэг цэгээс нөгөө цэг рүү тээвэрлэх үйл ажиллагаа юм.

- Холын тээвэр нь тээвэрлэлтийн хугацаа урт бөгөөд алслагдсан газраас их хэмжээний материалыг тээвэрлэх үйл явцыг хэлнэ.

3.8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ АЖИЛ, ТҮР БАРИЛГЫН ЭЛЭГДЛИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

3.8.1 Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөвт өртөгт нүүлгэн шилжүүлэх ажил, түр барилгын элэгдлийн зардлыг тусад нь тооцож нэгдсэн төсвийн тооцоонд тусгана.

3.8.2 Машин механизм, тоног төхөөрөмж, түр барилга, үйлдвэр, заводыг нэг цэгээс объект хүртэл эсхүл объект хооронд нүүлгэн шилжүүлэх зардлыг Маягт №5, 5-1-н дагуу тооцно.

3.8.3. Авто замын барилга, засварын ажил явагдаж буй трассын дагууд машин механизм, тоног төхөөрөмжийг нүүлгэн шилжүүлэх ажлын зардлыг машин механизм, тоног төхөөрөмжийн нэгж машин цагийн үнэд багтаан тооцсон байна.

3.8.4. Нүүлгэн шилжүүлэх ажлын цалингийн зардлын хэмжээг тооцохдоо нүүлгэн шилжүүлэх ажлын зардлын дүнгээс 8.7 хувиар бодож төсөвт тусгах ба нүүлгэн шилжүүлэх ажил, түр барилгын элэгдлийн зардлын тооцоонд нүүлгэн шилжүүлэх ажлын зардлын дүнгээс (цалингийн зардал хассан дүн) хасаж тооцно.

3.8.5 Нүүлгэн шилжүүлэх ажлын нэмэгдэл цалингийн хэмжээг (нэмэгдэл, нэмэгдэл хөлс, ээлжийн амралт, шагнал урамшуулал) нүүлгэн шилжүүлэх ажлын зардлын цалингийн дүнгээс 40 хувиар тооцно.

3.8.6. Авто замын барилга, арчлалт, засварын ажил явагдаж буй трассын дагууд машин механизм, тоног төхөөрөмжийг нүүлгэн шилжүүлэхээс бусад тохиолдолд машин механизм, тоног төхөөрөмж, түр барилга, үйлдвэрийг төслийн талбайд нүүлгэн шилжүүлэх зардлыг төсөвт тооцно. Төслийн онцлог байдал, байршил, батлагдсан ажлын тоо хэмжээ, машин механизм, тоног төхөөрөмжийн ажиллах хугацаа, авто зам, замын байгууламжийг барих, арчлах, засварлах ажлын нормативт хугацаатай уялдуулан нүүлгэн шилжүүлэх машин механизм, тоног төхөөрөмж, түр барилга, үйлдвэрийн тоо хэмжээ, тээвэрлэх зайг үнэн зөв тооцно.

3.8.7. Түр барилгын элэгдлийн зардлыг ажлын зураг төсөл, техникийн шаардлага, Авто зам, замын байгууламжийг барих, арчлах, засварлах ажлын нормативт хугацаа”-нд үндэслэн, тусад нь төсвийн тооцоо хийж нэгдсэн төсвийн тооцоонд тусгана.

3.8.8. Түр барилгын элэгдлийн зардал гэдэг нь барилгын төслийн явцад түр хугацаанд ашиглагдах барилга байгууламжийн элэгдэл, хорогдлын зардлыг хэлнэ. Үүнд:

- Түр оффис, лабораторийн байр
- Ажилтнуудын түр байр, хоолны газар, халуун ус
- Түр агуулах, склад
- Түр цахилгааны шугам сүлжээ
- Түр хашаа, хамгаалалтын байгууламж зэрэг орно.

3.8.9. Түр барилгын элэгдэл тооцох үнийг ажил гүйцэтгэж байгаа бүс нутгийн зах зээлийн дундаж үнээр авч төсвийн тооцоонд тусгана.

3.8.10. Дансны үнэ, овор хэмжээний хувьд ойролцоо түр барилгын элэгдлийн зардлыг авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөвт ижил элэгдлийн хувиар тооцно.

3.8.11. Түр барилгын элэгдлийн тооцоог хийхдээ дараах үндсэн зарчмыг баримтлана. Үүнд:
а) Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын үед дахин давтан хэрэглэх боломжгүй түр барилга ашиглах тохиолдолд элэгдлийн зардал бодогдохгүй.

б) Түр барилгыг дахин давтан ашиглах боломжтой бол ашиглалтын норм, тухайн түр барилгын балансын үнэ, элэгдлийн хувийг тогтоож, холбогдох зардлыг тооцно.

в) “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль”-ийн 17.1-т “Албан татвар төлөгчийн нэг ба түүнээс дээш жилийн хугацаанд ашиглах хөрөнгөд элэгдэл, хорогдлыг дараах байдлаар тооцно” гэж заасан. (Хүснэгт №3)

Хүснэгт №3

№	Хөрөнгийн бүлэг	Ашиглах нийт хугацаа /жилээр/
---	-----------------	-------------------------------

		Ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувьд	Бусад
1	Барилга байгууламж, газрын тохижилт	40	25
2	Машин механизм, техник, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж	10	
3	Компьютер, дагалдах тоног төхөөрөмж, программ хангамж	2	
4	Ашиглах хугацаа нь тодорхой биет бус хөрөнгө /Үүнд ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл хамаарна./	Хүчин төгөлдөр байх хугацаанд	
5	Бусад хөрөнгө	10	

3.8.12. Авто зам, замын байгууламжийн барилга, засварын төсөлд ажиллах ажилтнуудыг ажлын талбай руу тээвэрлэх, буцаах зардлыг төсөвт тооцно. Ажилтнуудын тоо, ажлын талбай хүрэх зай, ээлжийн тоог ажилтны хөдөлмөр зарцуулалт, “Авто зам, замын байгууламжийг барих, арчлах, засварлах ажлын нормативт хугацаа, гүйцэтгэгчээс талбайд ажиллах ИТА-ны тоо, үе шатны ажилд зарцуулах цагийн норм”, төслийн байршлаас хамааруулан ажилтаныг тээвэрлэх зардлыг тооцно.

3.8.13. Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөвт өртөгт нүүлгэн шилжүүлэх ажил, түр барилгын элэгдэл, ажилтан тээвэрлэх зардлыг тусад нь тооцож нэгдсэн төсвийн тооцоонд тусгана.

3.8.14. Нүүлгэн шилжүүлэх ажил, түр барилгын элэгдэл, ажилтаныг тээвэрлэх зардлыг Маягт №5, 5-1, 5-2, 5-3-н дагуу тооцно.

4. БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫН ТӨСВИЙН ТООЦОО

4.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

4.1.1. Төсвийн энэхүү тооцоо нь авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажил гүйцэтгэгч байгууллагын барилга угсралтын ажлын төсөвт өртгийг тооцоолоход зориулагдана.

4.1.2. Барилга угсралтын ажлын (НӨАТ-гүй) төсөв нь объектын төсвөөр тооцоолсон шууд зардлууд, удирдлага, зохион байгуулалтын зардал, ашгийн зардал, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагааны зардал, барилга угсралтын ажлын даатгалын зардлаас бүрдэнэ.

4.1.3. Хоёр ба түүнээс дээш төсвийн тооцоонд орсон нэг төрлийн ажлуудыг барилга угсралтын ажлын төсвийн тооцоонд ерөнхий нэг нэрийн дор нэгтгэнэ.

4.1.4. Барилга угсралтын ажлын төсвийн тооцоог Маягт №3-н дагуу тооцно.

4.2. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЗАРДЛЫН ТООЦОО

4.2.1. Удирдлага, зохион байгуулалтын зардлын хэмжээг төсөвт тусгахдаа нийт цалингийн санг суурь болгон авна.

4.2.2. Удирдлага, зохион байгуулалтын зардлыг төсвийн тооцооны нийт цалингийн зардлын дүнгийн 63.5 хувиар тооцож төсөвт тусгана.

4.2.3. Удирдлага, зохион байгуулалтын зардлын бүтцэд дараах зардлууд орно. Хүснэгт №3-т үзүүлэв.

Хүснэгт №3

№	Зардлын зүйл анги	Нийт зардалд эзлэх хувь хэмжээ (%-иар)
1	Захиргаа аж ахуйн ажиллагсадын цалин	49.4
2	Захиргаа аж ахуйн ажиллагсадын НДШ	6.2
3	Ажилтнуудын өвлийн сул зогсолтын үеийн цалин, эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал	7.8
4	Шуудан холбооны зардал	1.1
5	Газрын төлбөр	0.6
6	Албан томилолтын зардал	1.7
7	Удирдлагын барилга байгууламжийн ашиглалтын зардал	1.6
8	Удирдах болон ИТА-ны үйлчилгээний авто машины зардал	13.2
9	Сургалтын зардал	4.4
10	Биет бус хөрөнгийн элэгдэл	0.2
11	Зөвлөгөө, мэдээлэл, аудитын зардал	0.4
12	Хэвлэн олшруулах техник хэрэгслийн ашиглалтын зардал	1.6
13	ТУЗ, хяналтын зөвлөл, бусад дээд байгууллагад төлөх шимтгэл	4.4
14	Бичиг хэрэг, техникийн ном, норм дүрэм худалдан авах болон архивын зардал	2.7
15	Шинэ санаачлага, оновчтой саналыг хэрэгжүүлэх зардал	0.3
16	Тендертэй холбоотой зардал	0.2
17	Кемпийн үйл ажиллагааны зардал	0.5
	Удирдлага, зохион байгуулалтын зардлын дүн	100

4.3. АШГИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

4.3.1. Төсөвт ашгийн зардлын эх үүсвэрээр ажил гүйцэтгэх үеийн байгууллагын нийт зардлыг нөхөх, байгууллага, ажиллагсдын нийгмийн баталгааг хангах, үйлдвэрлэлээ хөгжүүлэх зорилгоор хийгдэх хөрөнгө оруулалтын зардал, үндсэн хөрөнгийн засвар, шинэчлэлт, эргэлтийн хөрөнгийн өсөлт, ажилтан болон өндөр настанд үзүүлэх тэтгэмж тэтгэмж, шагнал урамшуулал, мэргэжилтэн бэлтгэх, татвар, хураамж зэрэг зардлыг санхүүжүүлнэ.

4.3.2. Ашгийн зардлын хэмжээг төсвийн тооцооны шууд зардлын дүнгийн 15 хувиар тооцож төсөвт тусгана.

4.3.3. Ашгийн зардлын бүтцэд дараах зардлууд орно. Хүснэгт №4-т үзүүлэв.

Хүснэгт №4

№	Зардлын зүйл анги	Нийт зардалд эзлэх хувь хэмжээ, %-иар
1	Үндсэн хөрөнгийн засвар, шинэчлэлт	14.27
2	Эргэлтийн хөрөнгийн өсөлт	16.30
3	Ажилтан болон өндөр настанд үзүүлэх тэтгэмж	1.84
4	Шагнал урамшуулал	3.44
5	Баяр ёслолын үйл ажиллагааны зардал	3.44
6	Мөрдөгдөж буй шийдвэрийн дагуу ажиллагсадад үзүүлсэн хөнгөлөлт	5.76
7	Мэргэжилтэн бэлтгэх зардал	0.46
8	Ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах, амралт сувилалын зардал	0.73
9	Орлогын албан татвар	3.50
10	Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	1.10
11	Байгууллагыг бэхжүүлэх зорилгоор урт хугацаатай зээл (лизинг)-ээр худалдан авсан машин механизм, тоног төхөөрөмжийн үндсэн төлбөр болон хүүгийн төлөлт, шимтгэлийн зардал	49.16
	Ашгийн зардлын дүн	100

4.4. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ТООЦОО

4.4.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд заасны дагуу үйл ажиллагааны зардлын хувь хэмжээг шууд зардлын дүнгээс 2.5 хувиар тооцож төсөвт тусган хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тус тус зарцуулна.

4.4.2. Энэ зардал нь “Авто замын салбарын үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагаа, хөдөлмөр хамгааллын иж бүрэн дүрэм”-ийн дагуу авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын туршид хийгдэх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагааны зардал юм.

4.4.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 26.5-д “Энэ хуулийн 26.2-т заасан хөрөнгийг дараах арга хэмжээнд зарцуулна” гэж заасан. Үүнд:

1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, сурталчилгаа;
2. Ажилтныг эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт хамруулах;
3. Ажилтныг сувилах, хөдөлмөрийн чадвар алдалтыг нөхөн сэргээх;
4. Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл;
5. Ажлын байр, үйлдвэрлэлийн орчны аюул, эрсдэлгүй байдлыг хангах;
6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бүтэц, ажилтан, зөвлөлийн чиг үүрэгт хамаарах үйл ажиллагаа;
7. Ажилтныг амь нас, эрүүл мэндийн даатгалд хамруулах;
8. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх бусад арга хэмжээ.

4.5. БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫН ДААТГАЛЫН ЗАРДЛЫН ТООЦОО

4.5.1. Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын даатгалын зардлыг төсөвт тооцох талаар захиалагч байгууллага ажлын даалгаварт тусгасан тохиолдолд төсвийн шууд зардлын дүнгээс 0.4 хүртэл хувиар даатгуулна.

4.5.2. Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын даатгал нь авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөл хэрэгжиж дуусах хугацаанд учирч болзошгүй аливаа эрсдэл, хохирлоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, хохирлыг нөхөн төлөх зорилготой даатгал юм.

4.6 НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ЗАРДЛЫН ТООЦОО

4.7.1. Авто зам, замын байгууламжийн барилга, арчлалт, засварын ажилд ногдуулах НӨАТ-ын хэмжээг Монгол Улсын “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль”-ийн 11 дүгээр зүйлийн 11.1-т заасны дагуу БУА-ын зардлын дүнгээс 10 хувиар тооцож нэгдсэн төсвийн тооцоонд тусгана.

5. НЭГДСЭН ТӨСВИЙН ТООЦОО

5.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

5.1.1. Нэгдсэн төсвийн тооцоогоор авто зам, замын байгууламжийн барилга, арчлалт, засварын ажлын нийт төсөвт өртгийн хэмжээг тодорхойлно. (Маягт №1)

5.1.2. Нийт хөрөнгө оруулалтын хэмжээг Маягт №6-н дагуу тодорхойлно. Хөрөнгө оруулалтын II, III бүлэгт хамаарах зардал, ажлын хөлсийг тухайн асуудал эрхэлсэн төрийн

захиргааны төв байгууллагын дангаараа болон бусад байгууллагатай хамтарч тусгайлан гаргасан шийдвэрээр тогтооно. Эдгээр шийдвэрүүд төсөв бодох нормын салшгүй хэсэг нь байна.

5.2. ТУСГАЙ ТӨРЛИЙН АЖИЛ БА ЗАРДЛЫН ТООЦОО

5.2.1. Төсвийн норм, нормативын баримт бичигт тусгаагүй бөгөөд хөрөнгө оруулалтад зайлшгүй оруулах шаардлагатай зардлыг тусгай төрлийн ажил буюу зардал гэнэ. Уг зардалд газрын төлбөр, авто замын зурваст орсон барилга, байгууламжийг нүүлгэн шилжүүлэх болон нөхөх төлбөр, Засгийн газрын шийдвэрээр тогтоосон хөнгөлөлт, эсвэл нэмэлт төлбөртэй холбоотой зардал зэргийг багтаана.

5.2.2. Тусгай төрлийн ажил ба зардлын хэмжээг Монгол Улсын Газрын тухай хууль, Татварын ерөнхий хууль, Газрын төлбөрийн тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт, Засгийн газар болон бусад субъектын баталсан эрх зүйн хэм хэмжээ тогтоосон баримт бичгийг үндэслэн тогтооно.

5.3. ХАЙГУУЛ, ЗУРАГ ТӨСЛИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

5.3.1. Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын хайгуул, зураг төслийн зардлын төсөв бодох норм дүрэм, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй тушаал шийдвэрийн дагуу тодорхойлно.

5.3.2. Инженерийн хайгуул, инженер-геологийн судалгаа, геодезийн ажлын зардал нь авто замын трассын хайгуул, судалгаа, трасс сонголтын үндсэн ажлууд болон тэдгээрийг гүйцэтгэхэд шаардагдах бэлтгэл ба дагалдах ажлуудын зардлыг, харин зураг төслийн зардал нь Монгол Улсын нутаг дэвсгэрт баригдах олон улс, улсын чанартай авто зам, нийслэлийн авто зам, орон нутгийн чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламжийг төсөллөх, зураг төсөл, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын зардлыг тус тус хамаарна.

5.3.3. Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын хайгуул, зураг төслийн зардалд дараах зардлыг тусгана.

